

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багахангай дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/59/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn Аудитор: Д.Нарантуяа Утас: 325093 Цахим хаяг: narantuyad@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 128
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ
ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ Д.ЭНХТАЙВАН
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Багахангай дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

• 002021856

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 81 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,280,475.00</u>	<u>8,364,585.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	10,280,475.00	8,364,585.00
354	Хангамжийн материал	10,280,475.00	8,364,585.00
35410	Бичиг хэргийн материал	674,800.00	672,400.00
35420	Аж ахуйн материал	6,711,975.00	6,711,975.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,935,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	21,510.00
35470	Бусад хангамжийн материал	958,700.00	958,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>53,909,841.46</u>	<u>36,297,276.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,909,841.46	36,297,276.08
392	Биет хөрөнгө	52,094,925.46	34,565,776.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	480,000.00	480,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-460,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,833,000.00	87,833,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-75,813,845.00	-79,677,145.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,554,260.00	36,554,260.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,470,209.00	-19,066,410.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,128,286.00	71,128,286.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-53,347,816.54	-62,397,464.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,467,000.00	20,467,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20,467,000.00	-20,467,000.00
39217	Ном	171,250.00	171,250.00
393	Биет бус хөрөнгө	1,814,916.00	1,731,499.31
39301	Програм хангамж	5,550,000.00	5,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,175,084.00	-5,258,500.69
39303	Бусад биет бус хөрөнгө	1,440,000.00	1,440,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>64,190,316.46</u>	<u>44,661,861.08</u>
413	Өглөг	00.00	374,020.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	6,532.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	367,488.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>64,190,316.46</u>	<u>44,287,841.08</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	64,190,316.46	44,287,841.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,440,000.00	1,440,000.00

51101	Өмч: - төрийн	1,440,000.00	1,440,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	62,750,316.46	42,847,841.08
51210	Өмнөх үеийн үр дүн	62,750,316.46	62,750,316.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-19,902,475.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	64,190,316.46	44,661,861.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	340,501,300.00	499,034,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	340,501,300.00	499,034,520.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	335,489,300.00	487,884,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	335,489,300.00	487,884,800.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,012,000.00	11,149,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,012,000.00	11,149,720.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	373,961,328.86	518,936,995.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,961,328.86	518,936,995.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,813,390.91	512,716,041.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,528,106.95	366,011,566.08
210101	Үндсэн цалин	144,954,566.95	212,439,468.30
210102	Нэмэгдэл	44,391,249.00	79,753,889.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,364,500.00	50,217,577.92
210104	Урамшуулал	17,817,791.00	23,600,630.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,170,983.47	45,738,965.98
210201	Тэтгэврийн даатгал	18,842,084.75	31,098,365.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,245,459.97	3,660,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,745,967.60	2,928,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	394,315.22	732,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,943,155.93	7,320,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,710,296.00	61,163,388.00
210302	Түлш, халаалт	5,879,896.00	5,879,808.00

210304	Байрны түрээс	52,830,400.00	55,283,580.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,495,699.40	2,603,489.97
210401	Бичиг хэрэг	3,542,312.00	599,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,883,187.40	700,889.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,397,644.00	950,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	254,056.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	418,500.00	353,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	682,400.00	1,607,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	682,400.00	1,607,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,200,076.01	17,978,916.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,808,392.01	10,636,032.03
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,500,000.00	6,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	411,800.00	67,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,484.00	67,484.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	671,000.00
210807	Газрын төлбөр	14,400.00	14,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,025,829.08	17,612,565.38
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,999,129.08	17,612,565.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,147,937.95	3,329,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	318,500.00	1,470,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	318,500.00	1,470,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,320,821.95	2,891,653.94
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	508,616.00	1,859,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	508,616.00	1,859,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-33,460,028.86</u>	<u>-19,902,475.38</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-33,460,028.86</u>	<u>-19,902,475.38</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>340,501,300.00</u>	<u>499,034,520.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	340,501,300.00	499,034,520.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	335,489,300.00	487,884,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	335,489,300.00	487,884,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,012,000.00	11,149,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,012,000.00	11,149,720.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>340,501,300.00</u>	<u>499,034,520.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	340,501,300.00	499,034,520.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	323,353,362.05	492,813,566.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,685,646.05	365,896,742.06
210101	Үндсэн цалин	150,999,317.10	212,324,644.29
210102	Нэмэгдэл	38,368,912.00	79,753,889.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,772,858.95	50,217,577.92
210104	Урамшуулал	15,544,558.00	23,600,630.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,877,700.00	45,752,100.00
210201	Тэтгэврийн даатгал	19,759,900.00	31,111,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,279,400.00	3,660,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,823,600.00	2,928,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,900.00	732,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,558,900.00	7,320,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,490,296.00	60,795,900.00
210302	Түлш, халаалт	5,879,896.00	5,512,320.00
210304	Байрны түрээс	51,610,400.00	55,283,580.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,700,500.00	2,617,340.00
210401	Бичиг хэрэг	1,451,200.00	593,440.00
210402	Тээвэр, шатахуун	1,729,200.00	722,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,617,644.00	948,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	254,056.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	648,400.00	353,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,023,400.00	1,607,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,023,400.00	1,607,150.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,575,820.00	16,144,334.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,944,136.00	8,933,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,500,000.00	6,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	411,800.00	67,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,484.00	67,484.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	493,000.00	539,000.00
210807	Газрын төлбөр	14,400.00	14,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,147,937.95	6,220,953.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	318,500.00	1,470,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	318,500.00	1,470,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,320,821.95	2,891,653.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,320,821.95	2,891,653.94
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	508,616.00	1,859,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	508,616.00	1,859,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,440,000.00	00.00	96,210,345.32	97,650,345.32
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,440,000.00	00.00	96,210,345.32	97,650,345.32
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-33,460,028.86	-33,460,028.86
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,440,000.00	00.00	62,750,316.46	64,190,316.46

D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,440,000.00	00.00	62,750,316.46	64,190,316.46
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,440,000.00	00.00	62,750,316.46	64,190,316.46
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,902,475.38	-19,902,475.38
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,440,000.00	00.00	42,847,841.08	44,287,841.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	517,638,400.00	484,993,146.06	32,645,253.94	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	517,638,400.00	484,993,146.06	32,645,253.94	93.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	486,414,500.00	483,522,846.06	2,891,653.94	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	366,017,800.00	365,896,742.06	121,057.94	100.0
210101	Үндсэн цалин	222,828,900.00	212,324,644.29	10,504,255.71	95.3
210102	Нэмэгдэл	112,416,300.00	79,753,889.06	32,662,410.94	70.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,042,100.00	50,217,577.92	-32,175,477.92	278.3
210104	Урамшуулал	12,730,500.00	23,600,630.79	-10,870,130.79	185.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,752,100.00	45,752,030.00	70.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	31,111,500.00	31,111,500.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,660,100.00	3,660,030.00	70.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,928,100.00	2,928,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	732,000.00	732,000.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,320,400.00	7,320,400.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,334,200.00	60,795,900.00	2,538,300.00	96.0
210301	Гэрэл, цахилгаан	228,100.00	00.00	228,100.00	0.0
210302	Түлш, халаалт	7,253,000.00	5,512,320.00	1,740,680.00	76.0
210303	Цэвэр, бохир ус	569,300.00	00.00	569,300.00	0.0
210304	Байрны түрээс	55,283,800.00	55,283,580.00	220.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,365,300.00	2,226,340.00	138,960.00	94.1
210401	Бичиг хэрэг	250,300.00	247,440.00	2,860.00	98.9
210402	Тээвэр, шатахуун	722,800.00	722,400.00	400.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	888,300.00	903,200.00	-14,900.00	101.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	142,400.00	00.00	142,400.00	0.0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	361,500.00	353,300.00	8,200.00	97.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,609,200.00	1,607,150.00	2,050.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,609,200.00	1,607,150.00	2,050.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,335,900.00	7,244,684.00	91,216.00	98.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,800.00	33,800.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,500,600.00	6,500,000.00	600.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	375,500.00	67,300.00	308,200.00	17.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,300.00	67,484.00	24,816.00	73.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,700.00	22,700.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	245,000.00	539,000.00	-294,000.00	220.0
210807	Газрын төлбөр	66,000.00	14,400.00	51,600.00	21.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,223,900.00	1,470,300.00	29,753,600.00	4.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,223,900.00	1,470,300.00	29,753,600.00	4.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,753,600.00	00.00	29,753,600.00	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,300.00	1,470,300.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	517,638,400.00	484,993,146.06	32,645,253.94	93.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	517,638,400.00	484,993,146.06	32,645,253.94	93.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	517,638,400.00	484,993,146.06	32,645,253.94	93.7
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	18.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,290,720.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,290,720.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,290,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	391,000.00
210401	Бичиг хэрэг	346,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,899,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,899,720.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,149,720.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,149,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,149,720.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 221,317.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүү байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 19,160.9 мянган төгрөгөөр, өр төлбөрийг 374.0 мянган төгрөгөөр, орлогыг 500.0 мянган төгрөгөөр, зардлыг 930.1 мянган төгрөгөөр тус тус дутуу, нийт хөрөнгийн дүнг 929.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогын ангиллыг 11,149.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд эхний үлдэгдлийг 340.0 мянган төгрөгөөр, тайлант оны орлогыг 500.0 мянган төгрөгөөр, төвлөрүүлэх шилжүүлгийг 1,859.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, зардлыг 1,359.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнг 26,084.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд урсгал шилжүүлгийн зардлыг 31,223.9 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардлыг 101.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 358.2 мянган төгрөгөөр илүү, 1,287.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Урьдчилгаа цалин 125,159.5 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулж бүртгээгүй зэрэг нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, МНС-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 6,970.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 797.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,172.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цалин хөлсний баримтыг холбогдох тушаал шийдвэртэй тулгахад нэр бүхий ажилтанд ажиллаагүй хугацаанд 797.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагаврыг бий болгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." заалтыг зөрчсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Няравын бараа материалын тайлангийн үлдэгдлийг тодруулга тайлан, дэлгэрэнгүй бүртгэлийн дүнтэй тулгахад бараа материалыг 852.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, тооллого хийсэн боловч тооцоо бодоогүй, 344.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан боловч үлдэгдлээр тайлагнасан нь бараа материалд бүртгэлээр тавих хяналт сулрах үр дагаврыг бий болгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 20-р зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эд хариуцагчийн тайланг сар бүр хянаж баталгаажуулах, хагас бүтэн жилээр тооллого хийж тооцоог бодож хэвших, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тооллогын баримт, дэлгэрэнгүй бүртгэлийн дүнтэй тулгахад тооллого хийсэн боловч тооцоо бодоогүй, 3,500.0 мянган төгрөгийн хөрөнгө нэршил зөрүүтэй, 1,476.2 мянган төгрөгийн хөрөнгийг ангилал зөрүүтэй бүртгэсэн нь хөрөнгө буруу бүртгэгдэх, хөрөнгөд тавих хяналт сулрах үр дагавар бий болгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 20-р зүйлийн 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, 20.2.9.”аж ахуйн нээж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; удирдах;” заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллого хийхдээ тооцоог бодож хэвших, нэр зөрүүтэй бүртгэсэн хөрөнгийн нэршлийг засах, хөрөнгийг зөв ангилан бүртгэх.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Өмнөх оны аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхэд үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг дахин үнэлээгүй. Энэ нь аудитын шийдвэр хэрэгжихгүй байх үр дагавар бий болгох, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" заалтыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хөрөнгө дахин үнэлэх хүсэлтийг хүргүүлсэн албан бичгийг хариуг авч аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүү байдлын тайланд нийт хөрөнгийн дүнг 929.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	929.6			1	929.6	1	929.6		
Санхүү байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 19,160.9 мянган төгрөгөөр , өр төлбөрийг 374.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	2	19,534.9	2	19,534.9			2	19,534.9		
Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг 500.0 мянган төгрөгөөр, зардлыг 930.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	2	1,430.1	2	1,430.1			2	1,430.1		
Санхүүгийн үр дүнгийн тайланд 11,149.7 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй бүртгэсэн.	1	11,149.7			1	11,149.7	1	11,149.7		
Мөнгөн гүйлгээний тайланд зардлын эхний үлдэгдлийг 340.0 мянган төгрөгөөр , тайлант оны орлогыг 500.0 мянган төгрөгөөр, төвлөрүүлэх шилжүүлгийг 1,859.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	3	2,699.0	3	2,699.0			3	2,699.0		
Мөнгөн гүйлгээний тайланд 1,358.9 мянган төгрөгийн зардлыг илүү тайлагнасан.	1	1,358.9			1	1,358.9	1	1,358.9		
Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнг 26,084.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	26,084.7	1	26,084.7			1	26,084.7		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд урсгал шилжүүлгийн зардлыг 31,223.9 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардлыг 101.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;	3	31,325.6	2	31,223.9	1	101.7	3	31,325.6		
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 358.2 мянган төгрөгөөр илүү, 1,287.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	2	1,645.9	1	1,287.7	1	358.2	2	1,645.9		
Урьдчилгаа цалинг тооцооны дансаар дамжуулж бүртгээгүй байна.	1	125,159.5			1	125,159.5	1	125,159.5		
Дүн	17	221,317.9	11	82,260.3	6	139,057.6	17	221,317.9	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэр бүхий ажилтанд ажиллаагүй хугацаанд 797.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	1	797.6	1	797.6								
Хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодоогүй байна.	1	0					1	0				
Эд хариуцагчийн тайланд бараа материалын үлдэгдлийг 852.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	852.3					1	852.3				
Тайланд 344.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан боловч үлдэгдлээр тайлагнасан.	1	344.0					1	344.0				
Үндсэн хөрөнгөд 3,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэршил зөрүүтэй бүртгэсэн байна.	1	3,500.0					1	3,500.0				
Хөрөнгийн шинж чанар агуулаагүй 1,476.2 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.	1	1,476.2					1	1,476.2				
Дүн	6	6,970.1	1	797.6	0	0	5	6,172.5	0	0	0	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 2 автомашиныг ашиглаагүй ч грашид байршуулж 4,243.6 мянган төгрөгийн түрээсийн зардал гаргасан байна.	1	4,243.6					1	4,243.6
Байгууллагад хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн авто тээврийн хэрэгсэлд хуульд заасны дагуу цэнхэр дэвсгэр бүхий улсын дугаар аваагүй байна.	1	0					1	0
Дүн	2	4,243.6	-	-	-	-	2	4,243.6

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-

